

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Алтангэрэлийн Гүрбямбаа	Дугаар	L054
Оршин суугаа аймаг	Дорнод	Оршин суугаа сум	Булган сум
Төрсөн газар	Дорнод аймгийн Булган сум	Төрсөн он	1933
Ажил мэргэжил	өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Тугийн сүм	Сүм хийдийн дугаар	ДОБГ 003
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 26	Ярилцлага авсан хүн	Ж. Одгарьд



Дорнод аймгийн Булган сумын Тугийн сүм

Бид Сүм хийдийн түүхэн товчоо төслийн хүрээнд Дорнод аймагт байсан сүм хийдүүдийн түүхийг, мэдэх хүмүүстэй уулзан бичиж тэмдэглэн авч нэгдсэн мэдээллийн сүлжээ болгох тийм ажилтай явж байна.

Би түүх сонирхон судалдаг хүн. Энэ утгаараа ч нутаг орондоо байсан сүм хийдийн газруудыг судлан хуучны настай хүмүүстэй уулзан нэлээд зүйл сонсон тэмдэглэж ном сонинд хэвлүүлэх зэргээр хүмүүст хүргэж байсан.

-Дорнод аймгийн Булган сумын Чулуунбаатар гуай та хоёр Тугийн сүмийн тухай ном бичсэн байна. Тэгээд ер нь та Булган сумд байсан өөр сүм хийдүүдийн талаар юу мэдэх вэ, тэр тухайгаа ярьж өгөөч.

Мэдэх юм муутай л даа. Би чинь одоогоор л настай хүн болохоос биш тэр талаар мэдэх тухайд бол залуу хүн байхгүй юу. 70 жил шашны эсрэг үзэл суртлаар явчихсан. Яахав сонссон дуулсан юм байвал байх л юм. Хуучны лам нар л энэ тухай сайн мэднэ дээ. Чулуунбаатартай уулзсан уу?

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.
© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

-Уулзсан.

Манайд суваргачин гэдэг отог буй болсон. Тэр нь ямар учиртай гэхээр Шолойн гэрээслэлийн дагуу шарилыг нь чандарлуулахад баруун гарын шууны яс шаталгүй үлджээ. Тэр яс, чандарыг хоёр алтан суварганд агуулж суваргыг шүтээн болгон тахих болжээ. Тахих харж хамгаалахад хошуу бүрээс хоёр хоёр өрх айл ирүүлж харж байсан ба энэ айл өрхүүд нь Суваргачин отог болсон түүхтэй юм. Би та нарын ажилд нэмэр болох болов уу гээд Тугийн сүмийн тухай, хэдэн онд ямар хийд байгуулагдаж байсан он цаг, наашлаад лам нарын бослого тэмцлийн тухай зэрэг эмхтгэж бичсэн материалаа өгье. Энд миний сонссон дуулсан зүйл, бусад ном зэргээс ашигласан зүйл ч байгаа.

-За баярлалаа.

Тэр Баянтүмэний лам нарын бослого чинь одоогийн үүднээс аваад үзвэл буруутгах аргагүй л юм. Хувьсгалаар та нар шашнаа шүт гэж эрх чөлөөг нь өгчихөөд тэгээд шашин шүтлээ гээд буруутгаад байдаг. 1926 оны намар Баянтүмэн хан уулын хошууны гол хүрээ-Урд хүрээний лам нар бослого гаргаж байсан. Мөн би та нарт бичиж өгсөн материалд хэлмэгдүүлэлтийн тухай дурдсан байгаа. Ер нь би аймгийн хэмжээгээр мэдэхгүй. Булган сумыг л гадарлана. Миний сум юм л даа. Эндээс 50 хан км. Булган сумаас 1934 оноос эхлэн лам, хар, хуучин төрийн зүтгэлтэн, залан, захирагч, мээрэн зэрэг албан тушаалтай 160 гаруй хүнийг хилсээр эсэргүү хэмээн баривчилж 117-г нь бүүдан алжээ. Тэдний дотор шашны өндөр боловсролтой төрөл бүрийн мэдлэг мэргэжилтэй хүн байсныг “Цагаан ном”-д гаргасныг түүж үзвэл 15 маарамба, 28 гавж, 18 аграмба, 38 аранжинба байжээ. Энэ бол ганцхан сумын жишээ. Энэ бол архивын баримт. Настнуудын дуртгалд манай хошуунд 7 хийд хүрээ байсан гэж хэлдэг байсан.

1. Түмэн-Өлзийтийн хойд, урд хийд

2. Ялгуулсан хутагтын хоёр хийд

3. Дэчин гэгээний хийд

4. Гүний хийд

5. Угтамын хийд

Гэтэл сүүлд архивын материалд 8,9 ч юм шиг байгаа юм. Тэгээд 1930-аад он болоход Дорнодын 49 хийд байсан гэж байна лээ. Түрүүчийн тэр 7 гэдэг бол яахав. Зөвхөн нэг хошуун дотроо байсан байгаа. Тэр 49 гэдэг бол Дорнод аймгийн бүх хошууг оруулсан юм шиг байгаа юм. Егүзэр хутагтынх хүртэл манайд ордог байсан юм шүү дээ. Эднийг хамруулаад л ярихлаар 49 болж байгаа л даа. Тэгээд одоо энэ хошууны эрчүүдийн 80% нь сүм хийдэд суудаг байсан гэсэн архивын материал байгаа юм л даа.

Бас нэг зүйл сонирхуулахад Х.Пэрлээгийн “Монгол ард улсын эрт дунд үеийн хот суурингийн товчоо” номд “Цагаан-Овоо, Булган, Хөлөнбуйр сумын нутгийн заагт байгаа Х-ХI зууны Хятаны үеийн хотын үлдэгдэл Барс хотын балгасыг 1731 онд Монголоор явсан Хятадын жуулчин Гун-Чжи гэдэг хүн “Хоу-чи-сай-лу” гэдэг тэмдэглэлдээ “Сэцэн хан айсгийн Далай бэйсийн хошуунд Барс хот байна. Хотын дотор сүм бий. Тэр барилгын ард хоёр том суварга байна. Нэг суварга нь 7 давхар. Нөгөө нь 5 давхар юм. Тэр хоёр суварганы туурганд зурсан

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бурханы хөргүүд бүтэн хэвээрээ байна. 7 давхар суварганы дотор модон хайрцаг дээр тавиастай 3 тохой илүү урт чулуун ширээ бий. Тэр хайрцагт гурван цагийн бурхан Манзушир, Самандбада, дөрвөн Махранз, зурмал хуйлмал хадгалагдаж байна. ” гэж тэмдэглэсэн байна. ” Үүнээс үзэхэд X-XI зууны үед ч энэ нутагт Бурханы шашин байсныг харуулж байна.

-Та хийдүүдийн гар зургийг олж үзэж байв уу?

Манай энд Мэлс гэдэг зураач бий. Хийдийн зургуудыг зурдаг. Мэлс гэдэг чинь сонин нэр байгаа юм. Маркс, Энгельс, Ленин, Сталин гэдэг нэрсийг товчилж үүсгэсэн сонин нэртэй хүн. Эртний юм их судалдаг. Сан бэйсийн хүрээний зургийг хүртэл зурсан хүн байгаа юм.

-Булган сумын хийдүүдээс бас тодруулах юм байна?

Булганд бол Түгийн сүмээс өөр тогтмол юм байгаагүй. Тэр миний бичсэн номд бий. 16 ламтай тогтмол сүм байсан. Харин түр хурал бол Нүгний энэ тэр гээд байсан юм байна лээ.

-Баянтүмэн сумын баруун тал руу Ачит бэйсийн хүрээний. Тэнд хоёр газар олдохгүй байгаа юм. Юмын хурал, Хүйн хурал гээд.

Тэрийг ер нь түүх, архивт ч дурдаагүй түр зуурын л юм байсан байна л даа. Мэдэх ч үгүй юм байна.

-Тэр хурлын байсан газрыг нь багцаалах уу? Тэр хавьд байсан гээд.

Ёстой мэдэхгүй. Түр зуурын л юм байж. Хийдүүдийн лам нараас асууж сураглав уу?

-Балдандорж ламтай уулзана. Одоогоор хөдөө явчихаж.

Харин тэр чинь мэдэж магадгүй. Боловсролтой хүн байгаа юм.

-Хар эрэг гэдэг газар хийд байсан байх юм?

Хийд байсан гэж дуулаагүй. Хар эргийн балгас гэж дуулж байсан. Тэр газар нь хаа ч байдаг юм. Булган сумаас нааш л байгаа болов уу. Хар эргийн түүх дурсгалын газар гэж ярьдаг юм байна лээ. Хийд гэж сонсоогүй.

-Хэрлэн Барс хотоос хойшоо хурлын газар байсан уу?

Баруун хойшоо бол Саруул гүний хийд л байна. Тэрнээс өөр юм байгаагүй байх. Саруул гүний хийд голынхоо хойд талд. Одоо тэр Содов гуай л мэдэж байгаа байх. Уулзсан уу?

-Уулзсан.

Содов гуай яг мэдэх хүн. Залуухан байхдаа сууж байсан хүн. Тэгээд ер нь байхын хувьд байсан л байлгүй. Би мэдэхгүй юмаа мэдэхгүй байгаа юм чинь. Манай хойд чигийн буриад сумдуудад дуган дацан байсан. Ийшээгээ болохлоор Алтан-Очиртын гээд Матадын хийд байсан. Халх голын тэр лүү болохоор Халхын сүм гээд. Тэр чинь одоо сүүлдээ Хятадынх ч болсон уу яасан. Ингээд хошуу хошуундаа юм байлгүй яахав. Егүзэр хутагтынх чинь Сүхбаатар аймагтаа орно гэхдээ хуучин бол энэ л аймгийнх.

-Чойбалсан сумын хийдүүд? Ямар ямар хийдүүд байсан бэ?

За байз. Чойбалсангийнх чинь юү билээ? Ламхайнх. Дэчин гэгээний хийд чинь одоогийн Сэргэлэн сумын хавьцаа байсан болов уу? Ялгуулсан хутагтын, Хөгшний гээд байсан.

-Гурван баяны хийд?

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Гурван баяны хийд ч нэг их том хийд байгаагүй байх. Гурван баяны энгэрт жижиг нэг тийм түр хурал байсан юм байна лээ. Гурван баян гэдэг чинь Чойбалсан сумаас зүүн тийш байгаа. Маршал Чойбалсангийн төрсөн нутаг шүү дээ.

-Талбайн тайж нарын хурал гэж ямар хурал байсан юм бэ?

Талбайн тайж нарын хурал гэж яг тэнд байгаа юм. Гурван баяны энгэрийн чинь голын хойд талыг Хэрлэн цагаан талбай гэдэг байхгүй юу.

Чойбалсангийн төрсөн газар.

-Тэгвэл Гурван баяны хийд, Талбайн тайж нарын хурал хоёр чинь нэг хийд болж байна уу?

Одоо ер нь газар нь л нэг газар даа. Дотроо хоёр янз байсан юм уу үгүй юу.

-Юншээв хурал гэж ямар хурал байсан юм бол?

Чойбалсан сумаас арай урдүүр. Одоо энэ ийшээ Жаргалант гэж байсан. Арав Жаргалант гэж ердөө энэ Хан уулын энүүгээр байгаа. Тэгээд энэ Чойбалсан сумын нутагтай залгаа энүүхэн газарт еншөөв тайж нар байсан юм гэнэ лээ.

-Мээрэнгийн хурал гэж дуулсан уу?

Тийм юм дуулаагүй. Жаахан настай лам таараасай. Тэгвэл юм хэлнэ дээ.

-Роломжав гэдэг хүнийг дуулсан уу? Настай хүн.

Өө танина. Одоо 100 дөхөж байгаа хүн. Энүүхэн зүүн урагшаа байгаа. Аймгийн төвд ч байж магадгүй. Би тэр хүний 90 насны ойг зохион байгуулж байсан хүн байхгүй юу. Одоо бол 95,6 хүрч байгаа. Ухаан санаа саруулхан. Энүүхэн зүүн урагшаа нутаглаж байгаа байх.

(Гүрбямбаа гуайн өөрийн бичиж өгсөн материалыг дор буулгав)

“Чингисийн шүтээний сүм буюу-Тугийн сүм:Ачитын хошууны ноён Цэрэндоржийн Минжүүдорж /1806-1866/,Саруулын хошууны ноён Жамсранжавын Дарамжав /1825-1869/ нарын үед Саруулын хошууны Баян-Эрхт хавийн ардууд мал хунаргүй шахам болж маш ядуурч амьдрахын аргагүй боллоо харж үзээч гэсэн хүсэлт өргөдөл

Сэцэн хан аймгийн Хэрлэн барс

хотын Чуулган газарт ирсээр байсан тул хоёр түшмэл явуулж газар дээр нь үзэхэд тэр хавийн айлуудын ихэнх нь уранхай цоорхой бүрээстэй, умгар хар гэрүүдтэй, гадна 5-10 хонь ямаатай, ганц хоёр үнээ, унааны ганц хоёр мориноос өөр юмгүй үнэхээр Яядуурсныг чуулган даргад илтгэжээ.

Чуулган дарга чин ван Тогтохтөр төрөлхийн ухаалаг зан, ард түмний зан заншил, шүтлэг бишрэлийг түшиглэн урьд нь олон газар сүм хийд байгуулж, Халхын голын эрэгт Жанрайсаг бурхан бүтээж, өөрийн хошуундаа / Илдэн Жон вангийн хошуу/ сургууль байгуулах, эдийн засгийн элдэв аргаар ард түмнийхээ амьдралыг дээшлүүлж байсан туршлагаа үндэслэн Баян-Эрхт хавийн ядуучуудын амьдралд туслах нэг арга сэджээ.

Хамаг монголын үеэс уламжлалтай Хараа ихт хар түг нь дайн байлдаан болон гай гамшиг зэргийг зайлуулан дарах зорилгоор тахилга догшруулалт үйлддэг байсныг мэддэг ч байсан байж болох юм. үүнээс

Энэхүү нэр дурдсан хүний аман ярилцлагын үгчилсэн тэмдэглэл нь зөвхөн ярилцагчийн хувийн мэдээллээс бүрдсэн болно.

© Монголын Урлагийн Зөвлөлийн Соёлын Өвийн Хөтөлбөр, Монголын Сүм хийдийн түүхэн товчоон

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

санаа авч ядуурлын гай гамшигаас ард түмнээ аврахын тулд Баян-Эрхтэд эзэн Чингисийн хар сүлдний элч сүлд буюу хувилбарыг залах , Чингисийн шүтээний сүм байгуулж, түүний жас хөрөнгийг түшиглүүлэн тэр хавийн ядуучуудыг ажил амьдралтай болгохоор Баян-Эрхт дээр эзэн Чингисийн хар сүлд бүхий сүм байгуулна гэж Минбэйсийн хошуу, Саруул гүний хошуу даяар зарлаж хандив өгөхийг хүсчээ.

Ингээд эзэн Чингисийн сүнс сүлд болон монгол түмнийг даян дэлхийд цуурайтуулсан нэр төртэй хар сүлдийн элчийг өөрийн нутагтаа залах аз завшаан тохиолдсонд бэлэгшээсэн тус хошууны ядуу буурай ардаас эхлэн баячууд, ноёд түшмэд хүртэл бүхий л бололцоогоо дайчлан хандив өргөж богино хугацаанд асар олон мал хөрөнгө цугларчээ.

Тугийн сүмийн жасад хандиваар цугласан олон суурь хонь, адуу, үхрийг маллах ахлах, туслах малчид, малын үс ноос авч сүр дээс бэлтгэх, арьс элдэх, сүү цагаа боловсруулах, малчдын гэр тэрэг бэлтгэх дархчууд сүмд суух хориод ламд үйлчлэх гээд олон тооны ядуучууд ажил амьдралтай болж одоогийн хэлээр бол олон хүний ажлын байр бий болгосон юм гэнэ лээ гэж өвөгчүүд ярьж билээ.

Тугийн сүмийн гаднах зохион байгуулалт

Өвгөдийн ярьсны дагуу би өөрөө Баян-Эрхт дээр очиж сүмийн бусад хашаа барилгын туурь суурийн бүдэг тэмдэгийг ч хэмжиж, сүмийн ганц бүтэн хөх тоосгийг ч авч билээ. Баян-Эрхт нь эртний түүхт Бар хотоос зүүн урд зүгт Хэрлэн голын урд тэр хавьдаа өндөрлөг, шовх толгой байна.

Түүний орой дээр гол давхар сүм нь байсан бөгөөд энэ нь хүндэтгэл ёслолын чанартай, нэр хүнд гоёмсогоороо нэрд гарсан болохоос биш хэмжээ жижигхэн, ердөө л 8*12-м-ын орчим харьцаатай талбайтай түүний зүүн талд нэг жижиг байшин буюу сүм байсан бололтой. Гол сүмээс урагш 6х8 м-ын нэгэн суурь байна. түүнээс урагш 4х8 м-ын жижиг байшин буюу сүмийн ор бий. Түүнээс урд Баян-Эрхт толгой урд энгэрт шахам 12х18 м-ын том сүм буюу хашааны суурь бий. Энэ бол 16 лам ба гэсгүй үнзад зэрэг хориод лам байнга сууж хурал хурдаг хөх сүм байсан гэдгийн суурь бололтой. Түүнээс зүүн урагш дөчөөд метрт 20х30 м-ын орчим хэмжээний суурь байсан нь настнуудын хэлдгээр хогийн хонхор гэдэг нь бололтой. Тугийн сүмийг 27 см урт, 13 см өргөн, 5 см зузаан хөх тоосгоор барьсан байлаа. Харин энэ тоосгийг гаднаас авчирсан үү? Эндээ хийсэн үү гэдгийг мэдэх баримт олдоогүй бөгөөд настнуудын ярьснаар сүмийн зүүн хойно тоосго хийдэг бааюуны газар байсан гэдэг.

Тугийн сүмийн ар талыг налаад Баян-Эрхтийн овоо, түүнээс хойш 25 м орчимд лам нарын овоо гэж байжээ. Ахмад настан Бизъяагийн Балдан ярихдаа Сүмийн ар талд дээрээ алтан ганжир /дог/тай дороо гурван тулгууртай маш өндөр мод байдаг. Үүнийг чийга ямпай гэдэг. Энэ нь эзэн хаанд мэдэлтэй / хааны мэдлийн / сүмд байдаг гэлцдэг гэсэн билээ. “ Чингисийн онгон шүтээний тайлга тахилга” номонд хараа ихт хар сүлд /туг/ нь ямагт харуул хамгаалалттай, орон нутагтаа хөдөлгөөнгүй суурин байж хаан эзнийхээ ажил үйлс монгол түмнийхээ хувь заяаг хариуцаж байдаг.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Харин элч сүлд бол дайны талбарт хөлөг баатруудтайгаа явж хараа ихт хар сүлдтэйгээ мөнх тэнгэрээр холбогддог байсан учраас хар сүлдийг байнга гадаа байлгадаг байжээ. “ Элч сүлд” гэдэг нь хар сүлдийн элч төлөөлөгч гэсэн утгатай ажээ.

Манай тугийн сүмийн гадна байдаг байсан Хар туг нь Хараа ихт хар сүлдийн элч төлөөлөгч байжээ. Мөн нутгийн ахмад настан Борын Жигжид ярихдаа “ Тугийн сүмийн гадна байдаг боодолтой тугийн дээд талд дугуйрсан хялгасан цацагтай байсан” гэсэн нь уг ... тайлга тахилга номонд сүлдийн шилбийн /иш/ орой дахь царын хөвөөг дагуулан есөн ес наян нэгэн нүх цоолж хөхөл /азарганы дэл/ тогтоосон байна” гэсэнтэй таарч байна.

Тугийн сүмийн дотоод байдал

Их эрдэмтэн Бямбын Ринчен бичихдээ ... зүүн монголд Чингэс хааны дурсгалд зориулсан хоёр сүм байсан... Баян-Эрхтий гэдэг газар байгуулсан сүмийг Чингис хааны шүтээний сүм хэмээн нэрлэсэн байна. Энэхүү сүмд Чингис хаан хийгээд түүний их хатан, есөн өрлөг, жич Чингис хааны байлдан дагуулсан улс гүрний ахлагч нарын дүрийг бүтээн байгуулсан байжээ. Тэнд үнэт олдворууд болох хар туг буюу мөн Үүшиний их бага хэрээд энэ тугийг тахиж байсан тул хэрээдийн хар туг ч гэж нэрлэж байсан байна. Энэ тугийг их өмнө албын овоо гэдэг газар тахиж байсан ба сүүлдээ Үүшин хошуундаа алга болжээ.”